

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН ТӨВИЙН
ДАРГА, ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДАЛ
ЭРХЛЭХ АЛБАНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2001 оны 8-дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 138/40

Улаанбаатар
хот

Журам батлах тухай


Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

"Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны хооронд харилцан ажиллах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН
УЛСЫН ТӨВИЙН ДАРГА

А.ЭНХЖАВ



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ АЛБАНЫ
ДАРГА

Ц.БУЯНБАДРАХ



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН ТӨВ,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ
АЛБАНЫ ХООРОНД ХАРИЛЦАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2000 оны 172, 2001 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэр гаргуулах, удирдлагыг мэдээллээр хангахад энэ журмын зорилт оршино.

1.2. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны хооронд харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа

2.1. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбогдсон дор дурдсан мэдээлэл, судалгааг сар бүр Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд өгч байна. Үүнд:

а/ Гэрлэсэн /Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэний бүртгэл/;

б/ нас барсан;

в/ хүүхэд төрсөн;

г/ хүүхэд үрчилсэн;

д/ гэрлэлт цуцалсан;

е/ гэрлэлт сэргээн тогтоосон;

ё/ эцэг тогтоосон;

ж/ овог, эцгийн нэр өөрчилсөн.

2.2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба гадаадын иргэдийн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбогдох бичиг баримт /тодорхойлолт, лавлагаа гэх мэт/-ыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд өгч байна.

2.3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар иргэний харьяаллын асуудлаа шийдвэрлүүлсэн иргэдийн мэдээг тухай бүр Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд өгч байна.

2.4. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба Монгол Улсад байнга оршин суугч, цагаач, харьяалалгүй хүнд олгох регистрийн дугаарыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авч бүртгэл хөтөлж олгоно.

2.5. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь Монгол Улсын харьяатаас гарсан, харьяат болсон, хувийн хэргээр байнга болон удаан хугацаагаар оршин суугч, цагаач, харьяалалгүй хүн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэний мэдээллийн санг хөтлөх, ашиглахдаа шаардлагат бүхий л мэдээг хагас жил тутамд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд өгч, мэдээллээр хангаж байна.

2.6. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүний аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хариуцна.

2.7. Гадаадад албан ёсоор цагаачлан гарсан Монгол Улсын иргэний мэдээг тухай бүр Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлж байна.

Гурав. Бусад зүйл

3.1. Өөр өөрийн байгууллагад байгаа холбогдох мэдээллийн санг албан ажлын хэрэгцээнд харилцан ашиглах, бие биедээ шилжүүлэн ашиглуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

3.2. Гадаадын иргэдэд холбогдох зарим шаардлагатай асуудлыг хоёр байгууллагын даргын зөвлөлийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж болно.

3.3. Энэ журмын хэрэгжилтэд хоёр байгууллага хяналт тавьж дүнг хагас, бүтэн жилээр хэлэлцэж, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд идэвх зүтгэл гарган ажилласан ажилтныг шагнаж урамшуулж болно.

3.4. Хоёр байгууллагын хамтарсан уулзалтыг улирал тутам зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцон, тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Уулзалтад шийдвэрлэх асуудалтай холбогдох бусад байгууллага /яам, агентлаг/-ын төлөөлөгч урьж оролцуулж болно.

3.5. Хоёр байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтарсан хяналт шалгалт зохион байгуулж болно.

3.6. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны хяналтын улсын байцаагч нар эрх хэмжээнийхээ хүрээнд дотоодын буюу гадаадын иргэн, байгууллагын бичиг баримтыг шалгаж, зөрчил илэрвэл хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч энэ тухайгаа бие биедээ тухай бүр мэдэгдэж байна.